



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/633

Улаанбаатар хот

Нийслэлийн Зоонозын өвчин
Судлалын төвийн эргэлтийн бус хөрөнгийг
Балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,680,000 /есөн сая зургаан зуун наян мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг холбогдох байгууллагуудын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв /М.Мөнгөнцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн Хүрээ амаржих газар /А.Жаргал/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв /М.Мөнгөнцэцэг/, Нийслэлийн Хүрээ амаржих газар /А.Жаргал/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

Тушаал-2020
115060001855

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн
1/63 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт

Байгууллага: *Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв*

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглал- танд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
	Машин, тоног төхөөрөмж									
1	Ламинар бокс	BBS-V800	11/30/2019	ш	1	9,680,000.00	9,680,000.00	726,000.03	8,953,999.97	Хүрээ амаржих газар
Нийт хөрөнгийн дүн							9,680,000.00	726,000.03	8,953,999.97	